



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/10

Баян-Өндөр сум

┌ Тусгай зөвшөөрөл сунгах, хаягийн шилжилт ┐
хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 19.17, 19.18, 19.20, Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1, 5.3 дугаар зүйлийн 1, 5.5 дугаар зүйлийн 10 дах заалтууд, 6.1, 6.2 дугаар зүйл, Эрүүл мэндийн сайдын 2023 оны "Журам шинэчлэн батлах, тушаалд өөрчлөлт оруулах тухай" А/383 тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс"-ын 2024 оны 02 дүгээр сарын 14-ний өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийн дагуу сунгалт хийх байгууллагуудыг нэгдүгээр, хаягийн шилжилт хийх байгууллагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн газарт сар бүрийн мэдээ тайланг хугацаанд нь ирүүлж, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, стандартуудыг хэрэгжүүлэн ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудын захирал, дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөтийн хэлтсийн Бодлого төлөвлөлт хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Уртнасан)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны
 11/10 дүгээр сарын 14 ны өдрийн
 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

9043446 2020030036

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА
 ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ
 БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг, байршил	Хугацаа
1	Таван талын булаг ХХК-ын "Талын булаг" дотор, уламжлалтын клиник	Амбулатори болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ/	Цагаан -Чулуут баг 14-7 тоот	5 жил
2	Ган жинлүүр мөрөн ХХК-ын "Алтай" 2-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Жаргалант сумын Жаргалант баг, 03 байр	5 жил
3	Баян-Шүхэр ХХК-ын Баян-төгөл 1-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Уурхайчин баг, Төгөл худалдааны төвийн нэг давхарт	5 жил
4	Алирс ХХК-ын "Алирс-2" 1-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Согоот баг 6 р хороололын 2-р байрны 2 тоот	5 жил
5	Орхон эм хангамж ХХК-ын "Орхон-2" 1-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Хүрэнбулаг баг урт цагааны баруун жигүүрт	5 жил



Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны
4-р дүгээр сарын 14-ны өдрийн
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ХАЯГЫН ШИЛЖИЛТ ХИЙХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Шилжин орон хаяг, байршил
1	Чингүүн хишиг ХХК-ын "Эрдэнэт Хоспис"	Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ	4-р хорооллын 24-р байранд шилжиж орох